БАТЛАВ:
"МОНМАГ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.ТҮВШИНЖАРГАЛ / /

“МОНМАГ” ХХК

“МОНМАГ” ХХК-ИЙН
ДАРХАН–УУЛ АЙМГИЙН ШАРЫНГОЛ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОРЫН 2026 ОНЫ “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”

БОЛОВСРУУЛСАН:
"МОНМАГ" ХХК-ИЙН ХАБЭА ХАРИУЦСАН МЕНЕЖЕР / / Б.БИЛГҮҮН

2026 он

АГУУЛГА

1. ОРШИЛ
2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА
2.1 Засаг, захиргааны харьяалал, байршил
2.2 Төслийн ерөнхий мэдээлэл
2.3 Цогцолборын түүхэн товчоон
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
3.1 Уур амьсгал
3.2 Хөрс
3.3 Ургамлын бүрхэвч
3.4 Ус зүй
3.5 Амьтны аймаг
3.6 Нийгэм, эдийн засгийн байдал
3.7 Геологийн тогтоц
3.8 Агаарын даралт
4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
4.1 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ
5.1 Тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт
5.2 Байгаль орчны менежментийн арга хэмжээ ба үүрэг
5.3 Байгаль орчны дотоод хяналт шалгалт
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
6.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
6.3 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
6.4 Биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
7. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
11.1 Сургалт, сурталчилгаа, мэдээлэх тогтолцоо
12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР
14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
14.1 Байгаль орчны асуудал хариуцсан ажилтны үүрэг, чадавх
14.2 Компанийн нэгжийн оролцоо
15. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
16. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ
17. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
18. ХАВСРАЛТУУД

1. ОРШИЛ

Тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /цаашид "БОМТ" гэх/ нь "Монмаг" ХХК-ийн Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт байрлах тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын 2026 оны үйл ажиллагааны явцад байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан баримт бичиг юм.

Төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 13/5663 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлт болон "Галт уулын жуулчин" ХХК-ийн 2023 онд боловсруулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан /цаашид "БОННҮ-ний тодотгол" гэх/-д үндэслэн боловсруулав.

Төлөвлөгөөг боловсруулахдаа дараах хууль тогтоомж, журам, стандартыг баримтлав. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Усны тухай хууль
- Агаарын тухай хууль
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"
- MNS ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага ба хэрэглэх заавар

БОМТ нь "Монмаг" ХХК-ийн байгаль орчны нийцлийг хангах, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бүртгэж хянах, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутгийн иргэд болон холбогдох байгууллагад мэдээлэл өгөх үндсэн хэрэгсэл болно.

2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Зураг 1. Цогцолборын байршлын зураг

2.1 Засаг, захиргааны харьяалал, байршил

“Монмаг” ХХК-ийн Шарынгол хэсэг дэх Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор нь Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт, Дархан хотоос 60 км, Шарын голын нүүрсний уурхайгаас зүүн тийш 5 км, Шарын гол тосгоноос зүүн урагш 8 км зайд оршдог.

Хүснэгт 1. Ашиглалтын талбайн солбицол

Д/д	Нэгж талбарын нэр/хэмжээ (га)	Цэгийн дугаар	X	Y
1	Тэсрэх бодисын агуулахын бүс (13.7 га)	1	607924.10	5453331.97
		2	607949.29	5453399.85
		3	608009.14	5453546.38
		4	608252.24	5453502.25
		5	608297.16	5453483.65
		6	608308.86	5453478.84
		7	608395.96	5453441.15
		8	608348.45	5453321.78
		9	608522.61	5453249.26
		10	608463.38	5453104.74
		11	607991.57	5453298.08

2.2 Төслийн ерөнхий мэдээлэл

Монгол-Оросын хамтарсан хөрөнгө оруулалттай "Монмаг" ХХК нь 1991 онд байгуулагдсан бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Тэсрэх бодисын үйлдвэрлэл,
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, түүхий эдийн худалдаа,
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт,
- Тэсрэх материалын сорилт туршилтын лабораторийн ажил үйлчилгээ,
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлт,
- Тэсэлгээний ажил үйлчилгээ.

Монгол Улсад энгийн найрлагатай үйлдвэрийн тэсрэх бодис үйлдвэрлэх чиглэлээр Монгол-Оросын хамтарсан "Монмаг" ХХК-ийг байгуулах асуудлыг Засгийн газрын 1991 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсад анхны тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулахаар шийдвэрлэсэн. Компанийг байгуулахад дэмжлэг үзүүлэхийг Түлш, эрчим хүчний яам, Худалдаа, үйлдвэрийн яаманд тус тус үүрэг болгосон. Үүсгэн байгуулагчид 1990 онд ОХУ-ын Магаданы ВНИИ-1 эрдэм шинжилгээний хүрээлэнд үйлдвэрийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 1991 онд тоног төхөөрөмжийг угсарсан. Үйлдвэр 1992 оноос анхны бүтээгдэхүүнээ Багануурын нүүрсний уурхай болон бусад хэрэглэгчдэд нийлүүлж эхэлснээс хойш тасралтгүй ажиллаж байна.

Хүснэгт 2. Төслийн ерөнхий мэдээлэл

Мэдээллийн төрөл	Мэдээлэл
Төслийн нэр	Шарын гол салбар – Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	"Монмаг" ХХК
Регистрийн дугаар	2075318
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Интерном Б корпус, 3 дахь давхар
Төслийн байршил	Дархан-Уул аймаг, Шарын гол сум
Холбоо барих утас	+976-11-319162, +976-99114314
И-мэйл	info@monmag.mn
Тусгай зөвшөөрөл	Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл (2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн №895, 5 жилийн хугацаатай)
Жилийн үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 2600 тонн хүртэл АНФО тэсрэх бодис үйлдвэрлэх

2.3 Цогцолборын түүхэн товчоон

Тэсрэх материалын цогцолборыг анх 1965 онд Шарын голын нүүрсний уурхайн барилга байгууламжтай хамт барьж, агуулахын зориулалтаар ашиглаж эхэлсэн. Тухайн үед 250 тоннын багтаамжтай тэсрэх бодисын агуулах, тэсэлгээний хэрэгслийн агуулах, лаборатори, харуулын байр, усан сан болон хамгаалалтын хашаа барьж байгуулсан.

1981 онд уурхайн 2 дахь өргөтгөлийн дагуу 250 тоннын гурван тэсрэх бодисын агуулах, вагон татах лебедка, үерийн ус зайлуулах суваг, аянга зайлуулах төхөөрөмж болон 6/0.4 кВ-ын буурууллах дэд станцыг барьж ашиглалтад оруулсан.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1 Уур амьсгал

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын уур амьсгал нь эрс тэс, эх газрын онцлогтой. Жилийн дундаж агаарын температур -0.5°C орчим, хамгийн дулаан сар болох 7 дугаар сард +20.5°C, хамгийн хүйтэн сар болох 1 дүгээр сард -22.4°C (экстремум хүртэл -39°C) хүрдэг. Жилд дунджаар 275–290 мм хур тунадас унах бөгөөд нийт тунадасны 65 гаруй хувь нь зуны улирал буюу 6–8 дугаар саруудад ордог. 7–8 дугаар саруудад хамгийн их хур тунадас буюу 80–120 мм унадаг. Ган, шуурга харьцангуй их тохиолддог. Жилийн дотоод температурын зөрүү (амплитуд) 43–45°C хүрдэг.

3.2 Хөрс

Шарын гол сумын нутаг нь ойт хээрийн бүсийн өмнөд захад орших бөгөөд хойд хэсгээрээ хар хүрэн хөрстэй хэсэгцэг ойт нутаг, өмнөд болон зүүн хэсгээрээ хэмхдэст–элсэн хөрсний бүслүүрт хамаарна. Уурхайн ойролцоох нутагт байгалийн унаган хөрс техногенийн нөлөөгөөр ихээхэн өөрчлөгдсөн. Нутгийн хөрс нь шаварлаг-элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, ялзмагийн агууламж 1.5–2.5%, урвалын орчин (pH) 7.0–7.8 байна.

3.3 Ургамлын бүрхэвч

Талбайн орчимд ургамлын бүрхэвч техногенийн дарамтаас болж уналт, доройтолд орсон байна. Уурхайн нөлөөнөөс хол орших хэсгүүдэд таана, хөмөл, монгол өвс, хазаар өвс, шарилж, агь зэрэг хээрийн ургамал ургадаг. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 25–45% хооронд хэлбэлздэг.

3.4 Ус зүй

Тус нутаг нь Хойд мөсөн далайн ай савд хамаарах Хараа голын сав газарт оршдог. Байнгын урсгалтай гол горхи талбайн хэмжээнд байхгүй бөгөөд хур бороoны дараа богино хугацааны урсгал үүсэх хэд хэдэн хуурай сайр бий. Цогцолбор өөрийн усан хангамжийн эх үүсвэргүй, ундны усыг худалдааны цэгээс авч хэрэглэдэг. Орчмын нутагт газрын доорх усны гүн 15–35 м бөгөөд горим нь харьцангуй тогтвортой боловч хур тунадас, улирлаас хамааран өөрчлөгддөг.

3.5 Амьтны аймаг

Цогцолборын орчмын нутаг нь уурхайн дэд бүтэц, хот суурины болон үйлдвэрийн нөлөөлөлд байнга өртдөг техноген ландшафт бүхий газар тул зэрлэг амьтны шилжих хөдөлгөөн хязгаарлагдсан. Орчимд жижиг мэрэгчид, тал хээрийн шувуудын зарим зүйл тохиолдоно. Ховор, тусгай хамгааллын ангилалд орох амьтан тус нутагт бүртгэгдээгүй болно.

3.6 Нийгэм, эдийн засгийн байдал

Дархан-Уул аймгийн Шарын гол сум нь анх Монгол Улсын нүүрсний аж үйлдвэрийн томоохон төв болох "Шарын голын нүүрсний уурхай"-г түшиглэн байгуулагдсан түүхтэй. 1961 онд Зөвлөлт Холбоот Улсын техник, эдийн засгийн тусламжтайгаар уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж, 1965 онд уурхай ашиглалтад орсноор уурхайчдын хот суурин үүсэж хөгжсөн. Уурхайг дагаж олон мянган ажилчин, албан хаагч суурьшсанаар тус сум улсын эрчим хүч, түлшний салбарт голлох үүрэг гүйцэтгэх болсон.

Засаг захиргааны хувьд 1994 онд Дархан-Уул аймаг байгуулагдахад Шарын гол сум нь тус аймгийн нэгэн сум болон албан ёсоор зохион байгуулагдсан. Шарын гол сум нь хойд

болон зүүн талаараа Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр, зүүн өмнөд хэсгээрээ Сэлэнгэ аймгийн Мандал сумдтай, баруун болон баруун урд талаараа Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэртэй хиллэн оршдог.

Сумын төв нь аймгийн төв Дархан хотоос 45 км зайд байрладаг. Сум нь 70.3 мянган га нутаг дэвсгэртэй бөгөөд уулс, толгод бүхий хотгор гүдгэр ихтэй, ойт хээрийн бүсийн газарзүйн онцлогтой. Шарын гол сум нь дэд бүтцийн хувьд төвийн эрчим хүчний системд бүрэн холбогдсон, төмөр замын салаа болон хатуу хучилттай авто замаар улсын төвтэй холбогдсон давуу талтай. Мөн үүрэн холбоо, шилэн кабелийн интернэтийн сүлжээнд холбогдсон.

3.7 Геологийн тогтоц

Цогцолборын үйл ажиллагаа нь газрын хэвлийг ашиглах, малталт хийх ажилтай холбоогүй бөгөөд барилга байгууламж нь газрын гадаргад байрладаг тул геологийн тогтоцод нөлөөлөхгүй. Нутгийн геологийн тогтоцын дэлгэрэнгүй мэдээллийг БОННҮ-ний тодотголын суурь судалгааны хэсгээс харна уу.

3.8 Агаарын даралт

Шарын гол орчмын агаарын даралтын олон жилийн дунджийг (1961–1990 он) сүүлийн 30 жилийн (1990–2020 он) дундажтай жишиж үзэхэд жилийн дундаж утга 0.3 гПа-аар өссөн байна. Тухайлбал, хаврын улиралд (IV, V сар) агаарын даралт дунджаар 0.3–0.5 гПа-аар нэмэгдсэн байна.

Шарын гол өртөөний агаарын даралтын сарын явцаас үзвэл, I сард (905.2 гПа) хамгийн өндөр утгад хүрээд, түүнээс хойш буурсаар VII сард (898.4 гПа) хамгийн бага утгандаа хүрнэ. Үүний дараа агаарын даралт X сар (906.5 гПа) хүртэл аажмаар өсөж, XI, XII саруудад хэлбэлзэлтэй байна.

Сүүлийн 30 жилд Шарын гол өртөөн дээр хэмжигдсэн агаарын даралтын хамгийн их утгын жилийн дундаж 914.8 гПа байна. Энэ үзүүлэлтийн жилийн явцыг ажиглахад, хүйтний улирал эхлэхээс өмнөх X сард хамгийн их буюу 919.2 гПа-д хүрдэг онцлогтой. Шарын гол өртөөний түүхэн ажиглалтаар агаарын даралтын хамгийн их утга 1998 оны XII сард 935.4 гПа хэмжээтэй ажиглагдсан бөгөөд энэ нь олон жилийн дундаж даралтаас 3.6%-иар их юм.

Агаарын даралтын хамгийн бага утгын жилийн дундаж 890.7 гПа байна. Жилийн явцын хувьд дулааны улирал эхлэх үеийн IV сард хамгийн бага буюу 887.3 гПа хэмжээтэй байв. Шарын гол өртөөн дээрх ажиглалтын түүхэнд агаарын даралтын хамгийн бага утга 1963 оны III сард 872.1 гПа хэмжээтэй ажиглагджээ. Энэ нь олон жилийн дундаж даралтаас 3.5%-иар бага юм.

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

4.1 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Цогцолборын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эх үүсвэрийг БОННҮ-ний тодотголын 4 дүгээр бүлэгт тодорхойлсон. Үүнд: машин механизмын хөдөлгүүрээс ялгарах утаа, хорт хий; тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт; үйлдвэрийн объектын орчмын талхлагдал; ахуйн болон техникийн засвар үйлчилгээнээс гарах хатуу, шингэн хог хаягдал, бохир ус хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулах; тээврийн хэрэгслийн хөлхөлтөөс хөрс эвдэрч, ургамал устах; тоног төхөөрөмжийн дуу чимээ зэрэг болно.

Эдгээр нөлөөллийг шалгах хуудасны аргаар үнэлэв. Энэ арга нь цогцолборын үйл ажиллагааны явцад тухайн нөлөөлөл илрэх эсэхэд тулгуурлах бөгөөд илрэх нөлөөллийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, чиглэл, эрчмээр нь ангилж, харгалзах баганад "х" тэмдгээр тэмдэглэв (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, чиглэл, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Үргэлжлэх хугацаа		Чиглэл		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Бүцаж нөлөөлөх	Бүцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		х			х		х			х
Гадаргын усны өөрчлөлт		х		х		х				х
Агаарын чанарын өөрчлөлт	х		х	х		х			х	
Хөрсний бохирдол, эвдрэл	х				х	х			х	
Газрын гадаргын хэлбэр өөрчлөгдөх, талхлагдах	х				х	х			х	
Ургамлын бүрхэвч доройтох	х				х	х			х	
Зэрлэг амьтны орон зай хумигдах		х			х	х				х
2. Байгалийн нөөцийн ашиглалт										
Эрчим хүчний нөөц	х				х	х				х
3. Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл										
Ажлын байр нэмэгдэх (эерэг)	х				х				х	
Орон нутгийн орлого нэмэгдэх (эерэг)	х				х				х	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	х			х		х			х	
Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	х			х		х				х
4. Бусад нөлөөлөл										
Гал түймрийн аюул, осол	х			х		х		х		
Химийн бодис асгарах, алдагдах	х			х		х		х		
Ахуйн хаягдлаас орчин бохирдох	х			х		х			х	
Дүн (сөрөг нөлөөлөл)	**10**	**3**	**1**	**7**	**6**	**12**	**1**	**2**	**6**	**5**

Хүснэгт 3-т тусгасан ангиллын үндэслэлийг дор тайлбарлав.

- **Шууд нөлөөлөл:** үйл ажиллагааны улмаас тухайн орчинд шууд үүсэх нөлөөлөл. Цогцолборын хувьд агаарт утаа, тоос ялгарах, хөрс эвдрэх, газрын гадарга талхлагдах, ургамал устах, дуу чимээ үүсэх зэрэг хамаарна.
- **Шууд бус нөлөөлөл:** өөр орчноор дамжиж үүсэх нөлөөлөл. Асгарсан шатах тослох материал, ахуйн бохир ус хөрсөөр дамжин газрын доорх усанд нэвчих, хур борооны урсацаар бохирдуулагч бодис гадаргын усанд зөөгдөх, хүний хөдөлгөөн, дуу чимээнээс зэрлэг амьтан дайжих зэрэг хамаарна.
- **Өөрөө зохицуулагдах нөлөөлөл:** байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр өөрөө багасах нөлөөлөл. БОНҺҮ-ний тодотголын 4.1.1-д дурдсанаар тус нутаг байнгын салхитай тул хөдөлгүүрийн утаа, тоос агаарт сарниж, нөлөөлөл буурна.
- **Богино хугацааны нөлөөлөл:** зөвхөн тухайн ажил явагдах үед илэрч, ажил зогсоход арилах нөлөөлөл (утаа, тоос, дуу чимээ, шуурхай цэвэрлэсэн асгаралт).
- **Урт хугацааны нөлөөлөл:** экосистем сэргэх хүртэл үргэлжлэх нөлөөлөл (хөрс, газрын гадарга, ургамал, амьтны амьдрах орчин, газрын доорх ус).
- **Буцаж нөлөөлөх:** нөхөн сэргээлт, цэвэрлэгээ хийснээр анхны төлөвт ойртуулах боломжтой нөлөөлөл. Хөрс, газрын гадарга, ургамлын бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг 7 дугаар бүлэгт заасан нөхөн сэргээлтээр бууруулна.
- **Буцалтгүй нөлөөлөх:** сэргээх боломж хязгаарлагдмал нөлөөлөл. Газрын доорх ус бохирдсон тохиолдолд цэвэрших нь удаан бөгөөд хүндрэлтэй тул энэ ангилалд оруулав.
- **Хүчтэй:** хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хохирол учруулж болзошгүй нөлөөлөл. Зөвхөн гал түймэр, тэсрэлт, химийн бодисын асгаралт зэрэг ослын эрсдэлийг хамааруулсан бөгөөд хэвийн үйл ажиллагааны нөхцөлд хүчтэй нөлөөлөл тогтоогдоогүй.
- **Дунд зэрэг:** цогцолборын талбайн хүрээнд илэрч, бууруулах арга хэмжээ тогтмол шаардах нөлөөлөл.
- **Бага зэрэг:** хамрах хүрээ хязгаарлагдмал, хэвийн үйл ажиллагааны нөхцөлд орчинд мэдэгдэхүйц өөрчлөлт үүсгэхгүй нөлөөлөл.

Үнэлгээний дүнгээс үзэхэд нийт 13 сөрөг нөлөөллийн 10 нь шууд, 12 нь буцаж нөлөөлөх шинжтэй бөгөөд эрчмээр 5 нь бага, 6 нь дунд зэрэг, 2 нь хүчтэй байна. Хүчтэй гэж үнэлэгдсэн нөлөөлөл нь зөвхөн ослын эрсдэлтэй холбоотой тул түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 11 дүгээр бүлэгт, бусад нөлөөллийг бууруулах арга хэмжээг 6–12 дугаар бүлэгт, хяналтыг 13 дугаар бүлэгт тусгав.

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

5.1 Тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

БОМТ нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

2026 онд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Агаар, ус, хөрс, биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг 6 дугаар бүлэгт заасан арга хэмжээгээр бууруулах;
2. Ундны усыг зөвшөөрөлтэй худалдааны цэгээс авч, хадгалах савыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх (6.2 дахь хэсэг);

3. Элэгдэл, эвдрэлд өртсөн 10 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, 50 ширхэг мод тарьж арчлах (7 дугаар бүлэг);
4. Гал түймэр, тэсрэх бодисын болон химийн бодисын ослоос урьдчилан сэргийлэх (11 дүгээр бүлэг);
5. Хог хаягдлыг ангилан цуглуулж, аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар устгуулах (12 дугаар бүлэг);
6. Агаар, ус, хөрсний хяналт шинжилгээг БОННҮ-ний тодотголд заасан цэгүүдэд хөтөлбөрийн дагуу хийх (13 дугаар бүлэг);
7. Төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад хуваарийн дагуу тайлагнах (15 дугаар бүлэг).

БОННҮ-ний тодотголд цогцолборын үйл ажиллагааны онцлог, нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж, байгаль орчин болон хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн цар хүрээг тогтоосон. Төлөвлөгөөний арга хэмжээг тус тодотголын зөвлөмжид нийцүүлэн тусгав. Үйл ажиллагааны явцад дараах нөлөөлөл үүсэх боломжтой:

- **Хөрсөн бүрхэвч**: барилга байгууламж, агуулахын талбайг тэгшлэх, хамгаалалтын далан барих болон нэвтрэх зам талбайг бэлтгэх явцад хөрсний бүтэц алдагдах, хөрс хуулалт хийгдэх эрсдэлтэй.
- **Газрын гадаргуу:** тэсрэх бодисын агуулахын аюулгүй байдлыг хангах зорилгоор хийгдэх шороон байгууламжууд болон талбайн төлөвлөлтийн улмаас тухайн бүс нутгийн байгалийн рельеф, газрын гадаргуугийн хэлбэр өөрчлөгдөнө.
- **Ургамлан бүрхэвч:** үйлдвэрлэлийн бүс болон агуулахын эргэн тойронд аюулгүйн бүс тогтоох, дэд бүтэц байгуулах явцад тухайн хэсгийн ургамалжилт гэмтэх буюу устгагдах нөлөөлөл үүснэ.

Эдгээр нөлөөллийн цар хүрээ нь барилга байгууламжийн бүтээн байгуулалтын цар хүрээнээс хамаарч багаас дунд зэрэг байх бөгөөд нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой юм.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 11 дэх заалтад заасны дагуу жил бүрийн БОМТ болон Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-ийг БОННҮ-ний тодотголд тусгасан таван жилийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамаар /цаашид "БОУАӨЯ" гэх/ хянуулж батлуулна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох байгууллагад хүргүүлж, ОХШХ-ийн үр дүн болон төлөвлөгөөний хэрэгжилтийг 15 дугаар бүлэгт заасан хуваарийн дагуу оролцогч талуудад тайлагнана.

5.2 Байгаль орчны менежментийн арга хэмжээ ба үүрэг

Төлөвлөгөөнд тусгасан зардлыг урьдчилсан байдлаар тооцсон бөгөөд технологийн өөрчлөлт, ажлын ачаалал, хяналт шинжилгээний үр дүнгээс хамааран өөрчлөгдөж болно. Төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулахад нэн түрүүнд авах арга хэмжээ болон жил бүр тогтмол хэрэгжүүлэх менежмент, хяналт шинжилгээний ажлын зардлыг тусгав.

Арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг компанийн жилийн санхүүгийн төсөвт бүрэн тусгаж батална. Төлөвлөгөөний хэрэгжилтэд БОУАӨЯ, аймаг, сумын байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, байгаль орчны хяналтын улсын байцаагч хяналт тавина. Жилийн тайланд тухайн онд хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан зардал, гүйцэтгэлийн хувь, дараа онд хийх ажлыг тусгана.

5.3 Байгаль орчны дотоод хяналт шалгалт

Байгаль хамгааллын ажлыг ХАБЭА хариуцсан менежер зохион байгуулж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналтыг тогтмол хийнэ. Дотоод хяналтын үр дүнг сар бүр дүгнэж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгана.

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Хүснэгт 4. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн тоног төхөөрөмж болон автотээврийн хэрэгслийн ялгаруулалтаас агаар бохирдох	Тоног төхөөрөмж болон автотээврийн техникийн улсын үзлэгийг тогтмол хийлгэж, яндангийн шүүлтүүрийн бүрэн бүтэн байдлыг шалгах	Цогцолборын нутаг дэвсгэр	Жил бүр	90,000	Агаарын тухай хууль; MNS 4585:2016
2	Тэсрэх бодисын ачих, буулгах, тээвэрлэлтийн үеийн тоосжилт болон азотын ислийн ялгарал	Хуурайшилт ихтэй үед ачих, буулгах талбай болон цогцолбор доторх замд шаардлагатай бол усалгаа хийх; цогцолбор доторх замд хайрга дэвсэж засварлах; хурдны хязгаар тогтоож тэмдэг байршуулах	Цогцолбор болон түүнд хүрэх зам	Хуурайшилттай өдрүүдэд (4–10 сар)	860,000	MNS 4585:2016; Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
3	Ажилчдын эрүүл мэнд, ажлын байрны агаарын чанар	Ажилчдад тоосноос хамгаалах хошуувч (FFP2 болон дээш ангилал) олгох; жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах; хяналтын шинжилгээний үр дүнг ажилчдад мэдэгдэх	Нийт ажилчид (9 хүн)	Жил бүр	ХАБЭА-н жилийн төсвөөс	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
4	Агаарын бохирдлын хяналт, бүртгэл дутуу байх	Агаарын чанарын хэмжилтийн дүнг бүртгэлд тусгаж, бохирдуулах бодисын ялгарлын мэдээг жил бүр орон нутгийн байгаль орчны албанд хүргүүлэх	Цогцолборын нутаг дэвсгэр	Жилд 1 удаа	Дотоод зардал	Агаарын тухай хууль
	НИЙТ ЗАРДАЛ				**950,000**	

6.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Цогцолборын үйлдвэрлэлийн технологийн процесст ус ашигладаггүй, үйлдвэрлэлийн бохир ус үүсдэггүй. Ажилчдын ундны усыг зөвшөөрөлтэй худалдааны цэгээс зөөврийн саваар авч хэрэглэдэг бөгөөд цогцолбор өөрийн усан хангамжийн эх үүсвэргүй тул ус ашиглах дүгнэлт, гэрээ шаардлагагүй. Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 2 дахь заалтад усны хэрэглээг нарийвчлан тооцохыг заасантай холбогдуулан ундны усны хэрэглээг худалдан авалтын баримтаар бүртгэж, жилийн тайланд тусгана.

Гэсэн хэдий ч дараах тохиолдолд усан орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд:

- Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний үед шатах тослох материал алдагдах, асгарах;
- Тэсрэх бодисын түүхий эд, химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтийн үеийн зөрчил, ослын улмаас хөрс болон улмаар гадаргын ус бохирдох;
- Хур бороо болон хайлсан цасны ус талбайн гадаргаар урсаж, бохирдуулагч бодис зөөвөрлөх;
- Ахуйн хэрэглээнээс үүсэх бохир ус, хатуу хог хаягдлын буруу менежментээс шалтгаалан орчны усны чанарт нөлөөлөх эрсдэл.

Эдгээр эрсдэлийг бууруулах зорилгоор шатах тослох материалын хадгалалт, ашиглалтад хяналт тавих, асгаралтын үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангах, химийн бодис болон тэсрэх материалын хадгалалтын шаардлагыг мөрдөх, хог хаягдлыг ангилан цуглуулж, зөвшөөрөл бүхий байгууллагаар зайлуулах, ус бохирдох эрсдэлтэй хэсэгт тогтмол үзлэг хийх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Иймд хэвийн үйл ажиллагааны нөхцөлд гадаргын болон газрын доорх усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл бага гэж үнэлэв (Хүснэгт 3). Харин осол, шатах тослох материал, химийн бодисын алдагдал зэрэг хэвийн бус нөхцөлд усан орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй тул урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний үед шатах тослох материал алдагдах, асгарах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн техникийн бүрэн бүтэн байдалд тогтмол үзлэг, засвар үйлчилгээ хийх; тос, түлш алдагдсан эсэхийг өдөр тутам шалгаж, илэрсэн зөрчлийг шуурхай арилгах; засвар үйлчилгээ, тос солих ажлыг зориулалтын талбайд хийж, хөрс болон ус бохирдохоос хамгаалах; шатах тослох материал хадгалах хэсгийг битүүмжлэлтэй, асгаралт нэвтрүүлэхгүй суурьтай байлгах; асгарсан тос, бохирдсон материалыг тусгайлан	Цогцолборын талбай	Тохиолдол бүрт	Дотоод зардал	Усны тухай хууль

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
		цуглуулж, аюултай хог хаягдлын журмын дагуу зайлуулах				
2	Тэсрэх бодисын түүхий эд, химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтийн үеийн зөрчил, ослын улмаас хөрс болон улмаар гадаргын ус бохирдох	Түүхий эд, химийн бодис, тэсрэх материалын хадгалалтыг батлагдсан зураг төсөл, технологийн горим, холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулах; хадгалалтын талбайг хамгаалалттай, зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй байлгах; сав баглаа боодол, хадгалалтын нөхцөлд тогтмол үзлэг хийж, гэмтэлтэй сав, баглаа боодлыг нэн даруй солих; тээвэрлэлтийг зөвшөөрөгдсөн маршрутаар, шаардлага хангасан тээврийн хэрэгсэл ашиглан гүйцэтгэх	Цогцолборын талбай	Тохиолдол бүрт	Дотоод зардал	Усны тухай хууль; Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
3	Хур бороony болон хайлсан цасны ус талбайн гадаргаар урсаж, бохирдуулагч бодис зөөвөрлөх	Үйлдвэр, агуулахын орчны талбайн цэвэрлэгээ, эмх цэгцийг тогтмол хангах; бороо, цасны ус зайлуулах суваг, шуудуу, ус зайлуулах байгууламжийг төлөвлөж, тогтмол цэвэрлэх; түүхий эд, материал, хаягдлыг ил задгай хадгалахгүй байх; ус хуримтлагдах, үерлэх эрсдэлтэй хэсгүүдэд хяналт тавьж, шаардлагатай хамгаалалтын арга хэмжээ авах; үйлдвэрийн талбай орчимд тогтмол үзлэг хийж, бохирдлын эх үүсвэр илэрвэл шуурхай арилгах	Цогцолборын талбай	Тохиолдол бүрт	Дотоод зардал	Усны тухай хууль
4	Ундны ус бохирдох, чанар алдагдах	Ундны усыг зөвшөөрөлтэй худалдааны цэгээс авах; усны савыг сард 1 удаа угааж ариутгах, бүртгэл хөтлөх; ундны усны шинжилгээг 13 дугаар	Ундны ус хадгалах сав	Сар бүр	Дотоод зардал	MNS 0900:2018

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
		бүлэгт заасны дагуу хийлгэх				
5	Ахуйн бохир ус, жорлонгийн нүхнээс хөрс, газрын доорх ус бохирдох	Жорлонгийн нүх, ахуйн бохир усны цооногийн дүүргэлтийг шалгаж, шаардлагатай үед эрх бүхий байгууллагаар соруулан зайлуулах; ариутгал хийх; таг, ханын бүрэн бүтэн байдлыг хангах	Ахуйн барилгын орчим	Улиралд 1 удаа	Дотоод зардал	Усны тухай хууль
	НИЙТ ЗАРДАЛ				-	

6.3 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Үйлдвэрлэл, агуулахын үйл ажиллагаа нь тогтоосон хил хязгаар бүхий талбайд явагддаг бөгөөд хөрсний үржил шимт үеийг хөндөх, их хэмжээний газар шорооны ажил хийх шаардлагагүй. Технологийн процессоос хөрсөнд хаягдал нийлүүлэх нөхцөл үүсэхгүй тул хөрс бохирдох магадлал бага боловч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, талхлагдах нөлөөлөл талбайн хүрээнд байнга илэрдэг тул хөрсөнд үзүүлэх нөлөөллийг дунд зэрэг гэж үнэлэв (Хүснэгт 3).

Хөрсөн орчинд дараах тохиолдолд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд:

- Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний үед шатах тослох материал асгарах;
- Тэсрэх бодисын түүхий эд, химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтийн үеийн зөрчил, сав баглаа боодлын гэмтлээс шалтгаалан хөрс бохирдох;
- Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлын буруу хадгалалт, менежментээс хөрсний бохирдол үүсэх;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, талбайн ашиглалтаас хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх;
- Осол, аваарийн нөхцөлд химийн бодис болон бусад бохирдуулагч материал хөрсөнд нэвчих боломж.

Хүснэгт 6. Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний үед шатах тослох материал асгарах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тос, түлш алдагдалд тогтмол үзлэг хийх; засвар, тос солих ажлыг зориулалтын талбайд гүйцэтгэх; асгарсан тос, бохирдсон материалыг тусгайлан цуглуулж зайлуулах; жолооч, механик ажилтнуудад асгаралтаас	Засварын талбай, агуулахын орчин	Тохиолдол бүрт	Дотоод зардал	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
		урьдчилан сэргийлэх зааварчилгаа өгөх				
2	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлын буруу хадгалалт, менежментээс хөрсний бохирдол үүсэх	Хог хаягдлыг ангилан ялгах; аюултай болон энгийн хог хаягдлыг тусад нь хадгалах; хог хадгалах талбайг хатуу хучилттай, хашаатай, тэмдэг тэмдэглэгээтэй болгох; тос, шүүлтүүр, бохирдсон материалыг битүү тусгай саванд хадгалах (зайлуулах ажлыг 12 дугаар бүлэгт тусгав)	Цогцолборын нутаг дэвсгэр	Жил бүр	300,000	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль; Хог хаягдлын тухай хууль
3	Осол, аваарийн нөхцөлд химийн бодис болон бусад бохирдуулагч материал хөрсөнд нэвчих боломж	Химийн бодис, түүхий эдийн хадгалалтын нөхцөлд тогтмол хяналт хийх; сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг шалгах; асгаралтын үед авах арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх; асгаралт саармагжуулах материал, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэх; ажилтнуудад ослын үеийн сургалт, дадлага хийх; бохирдсон хөрсийг тусгаарлаж, нөхөн сэргээх арга хэмжээ авах	Цогцолборын нутаг дэвсгэр	Сар бүр	Дотоод зардал	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
	НИЙТ ЗАРДАЛ				**300,000**	

6.4 Биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Хүснэгт 7. Биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Тарьсан мод, суулгац хатаж үхэх	Тарьсан мод, суулгацыг услах, бордох; 85%-иас доошгүй амьдралттай байлгах; хатаж үхсэн модыг нөхөн тарих	Цогцолборын нутаг дэвсгэр	Жилд 2 удаа (хавар, намар)	600,000	Ойн тухай хууль; MNS 5918:2008
2	Ургамлан бүрхэвч талхлагдах, устах	Талбайн гадна ургамлан бүрхэвчийг гэмтээхгүй байх; тээврийн хэрэгслийг	Цогцолборын орчин, 500 м радиуст	Жил бүр хяналт	Дотоод зардал	Байгаль орчныг хамгаалах

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
		тогтоосон замаар явуулах; ойр орчмын малчидтай хамтран ажиллах				тухай хууль
	НИЙТ ЗАРДАЛ				**600,000**	

7. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННҮ-ний тодотголд цогцолборын сул талбайн 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж байгуулахыг зөвлөсөн. Иймд мод тарилтыг жил бүр үе шаттайгаар нэмэгдүүлэх бөгөөд 2026 онд 50 ширхэг мод тарина. Модыг зонхилох салхины дээд талд, хашааны дагуу улиас, хайлаас зэрэг орон нутгийн уур амьсгалд дасан зохицсон төрлөөр тарина.

Хүснэгт 8. Нөхөн сэргээлт, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлт, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэр, агуулахын барилга байгууламж барих болон үйл ажиллагааны үед элэгдэл, эвдрэлд өртсөн талбайг техникийн нөхөн сэргээлтээр байгалийн унаган төрхөнд ойртуулах	Техникийн нөхөн сэргээлт: газар шорооны ажлын үед гарсан илүүдэл ул хөрсийг эвдрэлд орсон газарт (жалга, аса зэрэг) асгаж тэгшлэх; дарж булахдаа технологийн дагуу нягтруулж, байгалийн унаган төрхөнд ойртуулан хэлбэржүүлэх	Агуулах, үйлдвэрлэлийн нөлөөнөөс элэгдэл, эвдрэлд өртсөн талбай	га	10	150,000	1,500,000	2026 оны II–III улирал, 1 удаа	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль; MNS 5916:2008
2	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийж ургамлан бүрхэвчийг сэргээх	Биологийн нөхөн сэргээлт: орон нутгийн уур амьсгалын онцлогт тохирсон ургамал, мод, сөөг тарьж ургуулах; 50 ширхэг мод тарих	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай; цогцолборын орчим	га	10	250,000	2,500,000	2026 оны II улирал (тарилт), II–III улирал (усалгаа)	MNS 5918:2008
3	Цогцолборын орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг тогтвортой байлгах	Тарьсан мод, суулгацыг услах, бордох, хамгаалах; 85%-иас доошгүй амьдралтыг хангах; хатаж үхсэн модыг нөхөн тарих	Тарьсан 50 ширхэг мод, сөөг	ш	50	-	6.4 дэх хэсэг, Хүснэгт 7-д тусгасан	Жилд 2 удаа (хавар, намар)	Ойн тухай хууль; MNS 5918:2008

№	Нөхөн сэргээлт, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас заасан газрыг нөхөн сэргээх	Орон нутгийн удирдлагаас зааж өгсөн газарт нөхөн сэргээлт хийх (8 дугаар бүлэг)	Орон нутгаас зааж өгсөн талбай	га	10	-	Дотоод зардал	2026 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
						НИЙТ ЗАРДАЛ	**4,000,000**		

8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННҮ-ний тодотголын 7.3 дахь хэсэгт тус цогцолборыг биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах шаардлагагүй төсөлд хамааруулсан. Иймд энэ бүлэгт ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 8 дахь заалтад нийцүүлэн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд оролцох болон орон нутгаас заасан талбайг нөхөн сэргээх ажлыг тусгалаа.

7 дугаар бүлэгт заасан 50 ширхэг модыг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьж, тус хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлнэ. Арчилгааг Хүснэгт 7-д заасны дагуу гүйцэтгэх бөгөөд зардал нь 600,000 төгрөг байна. Мөн орон нутгаас зааж өгсөн 10 га газрыг Хүснэгт 8-ын 4 дэх мөрөнд заасны дагуу нөхөн сэргээнэ. Мод тарьсан, нөхөн сэргээсэн ажлын фото зураг, бүртгэлийг жилийн тайланд хавсаргана.

9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын ашиглалтын талбайн орчимд байнгын суурьшмал малчин өрх, айл гэр байхгүй. Улирлын чанартайгаар оторын малчин өрхүүд хөрш нутагт түр хугацаагаар нутаглах боловч цогцолборын аюулгүй бүсийн хэмжээнд байрладаггүй.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олгох шаардлага 2026 онд үүсэхгүй тул энэ чиглэлийн арга хэмжээ төлөвлөөгүй болно. Ирээдүйд шаардлага тулгарвал "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуульд заасны дагуу нөхөн олговор олгох арга хэмжээг тусгайлан боловсруулж хэрэгжүүлнэ.

10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгээр 2015 онд хийгдсэн угсаатны зүй, соёлын нөлөөллийн үнэлгээний судалгаагаар цогцолборын ашиглалтын талбайн орчимд аливаа соёлын биет өв, археологийн олдвор бүртгэгдээгүй болно. Иймд тусгай хамгаалалтын арга хэмжээ 2026 онд шаардлагагүй байна.

Гэхдээ үйл ажиллагааны явцад газрын хэвлийд ямар нэгэн соёлын биет өв, археологийн олдвор илэрвэл "Соёлын өвийг хамгаалах тухай" хуульд заасны дагуу:

- газрын хэвлийг ашиглах ажлыг даруй зогсоож;
- сум, дүүргийн Засаг дарга болон цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж;

- соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, зөвшөөрөл авснаар үргэлжлүүлэн ажиллана.

11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, ₮	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
1. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх							
Цаг агаарын гэнэтийн үзэгдэл (шуурга, аянга, борооны үер)-ийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох	Цаг уурын улирлын, сарын, 7 хоногийн урьдчилсан мэдээг тогтмол ашиглаж үйл ажиллагааг төлөвлөх; аянга зайлуулагчийн техникийн бүрэн бүтэн байдлыг хагас жилд нэг удаа шалгаж, газардуулгын хэмжилт хийлгэх; аюулын тохиолдолд ажлыг зогсоох горим боловсруулж батлах	Цогцолбор	Жилд	2 удаа	250,000	500,000	Гамшгаас хамгаалах тухай хууль
2. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх							
Гал түймрийн улмаас тэсрэх бодис асах, дэлбэрэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсох	Гал түймрийн аюулгүй байдлын сургалт, сурталчилгааг жилд 2 удаа зохион байгуулах; нийт ажилчдыг хамруулах; болзошгүй аюулын үед авах арга хэмжээний заавраар хангах	Нийт ажилчид	Жилд	2 удаа	-	Дотоод зардал	Галын аюулгүй байдлын тухай хууль
	Галын аюулгүй байдлын тоног төхөөрөмж (гал унтраагч, хоолой,	Цогцолборын бүх барилга байгууламж	Жилд	1 удаа	-	Дотоод зардал	Галын аюулгүй байдлын тухай хууль

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, ₮	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
	дохиолол)-ийг тогтоосон стандартын дагуу байршуулж, жилд 1 удаа техникийн хяналт хийлгэх; хугацаа дууссан гал унтраагчийг солих						
3. Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх							
Тэсрэх бодистой зохисгүй харьцсанаас гарах дэлбэрэлт, осол	Тэсрэх бодисын агуулах, үйлдвэрийн объектод нэвтрэх зөвшөөрлийн дэглэмийг чанд мөрдөх; агуулах, үйлдвэрийн объектын аюулгүйн зайг сахих; бүх ажилтанд ХАБЭА-н сургалт жилд 2 удаа явуулах	Цогцолборын нутаг дэвсгэр	Жилд	2 удаа	-	Дотоод зардал	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль; Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
Хүний эрүүл мэнд, амь насанд осол, аваараас хохирол учирч болзошгүй	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавих; анхны тусламжийн иж бүрдэл, асаралт цэвэрлэх багц (шингээгч материал, хүрз, битүү сав)-ыг ажлын байранд байршуулж бэлэн байлгах; хувийн хамгаалах хэрэгслийг 6.1 дэх хэсэгт тусгасны дагуу	Нийт ажилчид	Жилд	1 удаа	481,000	481,000	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, ₮	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
	олгох						
4. Химийн бодисын аюулаас урьдчилан сэргийлэх							
Аммонийн нитрат, дизелийн түлш асгарах, гал авалцаж задрахад хорт хий ялгарах	Аммонийн нитрат, дизелийн түлшийг тус тусад нь зориулалтын агуулах, саванд хадгалах; химийн бодисын аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудсыг ажлын байранд байршуулж, ажилчдад танилцуулах; химийн бодис асгарсан тохиолдолд бохирдсон хөрсийг тухай бүрт цэвэрлэх	Агуулах болон үйлдвэрийн бүс	Тогтмол	-	-	Дотоод зардал	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
НИЙТ ЗАРДАЛ						**981,000**	

11.1 Сургалт, сурталчилгаа, мэдээлэх тогтолцоо

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахад ашиглаж буй химийн бодисын найрлага, шинж чанар, хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээллийг химийн бодисын аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудсанд тусгаж, ажлын байранд байршуулна. Цогцолборын нийт ажилчдад сургалт, сурталчилгааг жилд 2 удаа зохион байгуулна.

12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн энгийн хог хаягдал	Хог хаягдлыг органик, хуванцар, цаас, металл гэж 4 ангилалд ялган битүү хогийн саванд хадгалах; Шарын гол сумын нэгдсэн хогийн	Цогцолборын нутаг дэвсгэр	удаа	7 хоногт 1	Дотоод зардал	Хог хаягдлын тухай хууль

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
		цэгт гэрээний дагуу 7 хоногт нэг удаа тээвэрлэх					
2	Хоёрдогч түүхий эд	Дахин боловсруулах боломжтой хуванцар, цаас, шил, металл зэргийг тусдаа цуглуулж, хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгжид нийлүүлэх	Цогцолборын нутаг дэвсгэр	кг	Тохиолдол бүрт	Дотоод зардал	Хог хаягдлын тухай хууль
3	Бүх нийтийн цэвэрлэгээ	Цогцолборын орчны тохижилтын цэвэрлэгээг хагас жилд нэг удаа зохион байгуулах; орон нутгийн иргэдийг оролцуулах	Цогцолборын нутаг дэвсгэр	удаа	2	Дотоод зардал	Хог хаягдлын тухай хууль
4	Аюултай хог хаягдал	АНФО тэсрэх бодисын шуудай, эмульсийн хайрцаг зэрэг аюултай хог хаягдлыг тусгай саванд хадгалж, эрх бүхий аж ахуйн нэгжээр гэрээний дагуу тээвэрлүүлж устгуулах; хог хаягдлын бүртгэл хөтөлж, жилийн тайланд тусгах	Зориулалтын талбай	кг	Тохиолдол бүрт	300,000	Хог хаягдлын тухай хууль
	НИЙТ ЗАРДАЛ					**300,000**	

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь цогцолборын үйл ажиллагааны явцад байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор ажиглалт, хэмжилтийг тогтоосон цэгт, тодорхой давтамжтайгаар явуулах удирдамж юм. Хөтөлбөрийн зорилго нь болзошгүй өөрчлөлтийг эрт илрүүлэх, арга хэмжээний үр дүнг тайлагнах, орон нутгийн захиргаа болон оршин суугчдад бодит мэдээлэл өгөхөд оршино.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх үүрэгтэй. Хэрэв бохирдлын хэмжээ нь байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илэрвэл мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хяналт шинжилгээнд агаар, ус, хөрс, ургамлын төлөв байдлыг хамруулах бөгөөд дээж авах, хадгалах, тээвэрлэх, шинжлэхдээ хүчин төгөлдөр стандарт, арга зүйг баримтална.

Дээж авах цэгүүдийг тодотголд заасан байршлаар сонгосон бөгөөд дээж авах, шинжилгээ хийх ажлыг итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлнэ. Шинжилгээний дүнг өмнөх онуудын үр дүнтэй харьцуулж, БОМТ-ийн жилийн тайланд тусгана.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Дээжийн тоо	Нэгж үнэ, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах стандарт
1	Агаар: NO_2, SO_2, CO_2, PM2.5, PM10-ийн агууламж	4 цэг: үйлдвэрийн байрны орчим; тэсрэх бодисын агуулахын үүд; албан конторын байрны урд; ачаа буулгах цэг	Жилд 2 удаа (II, IV улирал)	8	55,000	440,000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Гадаргын ус: ерөнхий химийн болон бактериологийн шинжилгээ, газрын тосны бүтээгдэхүүн	4 цэг: Шарын голын уурхайн ус зайлуулах шуудууны эхлэл, төгсгөл; үйлдвэрийн хашааны дагуух шуудууны эхлэл, төгсгөл	Жилд 2 удаа (ус байгаа үед)	8	46,000	368,000	MNS 6148:2010 Газрын доорх ус. Бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	Ундны ус, худгийн ус: ерөнхий химийн болон бактериологийн шинжилгээ, усны түвшин	2 цэг: цогцолборын ундны ус хадгалах сав; ойролцоох малчдын гар худаг	Жилд 1 удаа (III улирал)	2	76,000	152,000	MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ; MNS ISO 5667-11:2000
4	Хөрс: pH, ялзмаг, карбонат, Ca^{2+}, Mg^{2+}, K_2O, P_2O_5, механик бүрэлдэхүүн, хүнд металл (Cr, Pb, Cd, Ni, Zn)	4 цэг: тэсрэх бодисын агуулахын үүд; үйлдвэрийн байрны үүд; ачаа буулгах цэг; голтой хамгийн ойр хэсэг	Улиралд 1 удаа	16	65,000	1,040,000	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 3298:1991
5	Ургамал: зүйлийн бүрдэл, тархалт, доройтлын түвшин	2 цэг: цогцолборын урд болон хойд хэсэг	2 жилд 1 удаа (2027 онд)	–	–	–	Байгалийн унаган төрхөөрөө байгаа экосистемтэй харьцуулах арга
НИЙТ ЗАРДАЛ						**2,000,000**	

14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

14.1 Байгаль орчны асуудал хариуцсан ажилтны үүрэг, чадавх

"Монмаг" ХХК-ийн ХАБЭАБО хариуцсан менежер нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Цогцолборын үйл ажиллагааны байгаль орчны нийцлийг өдөр тутмын хяналтын дэвтэрт бүртгэж, сар бүр дүгнэлт гаргах;
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд биечлэн оролцож, лабораторийн дээж авалтыг хэсгийн лаборант, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Байгаль орчны асуудлаар гарсан зөрчлийг тухай бүрт шийдвэрлэж, удирдлагад мэдэгдэх;
- Нийт ажилчдад байгаль орчны сургалтыг ХАБЭА-н сургалттай хамт жилд 2 удаа зохион байгуулах;
- БОМТ-ийн хэрэгжилтийн жилийн тайланг боловсруулж харьяа яам болон орон нутгийн байгаль орчны байгууллагад хүргэх;
- Байгаль орчны хяналтын улсын байцаагчтай хамтран ажиллах, шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 10 дахь заалтад "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэхээр заасан. Төлөвлөгөөт аудитыг 2027 онд эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх бөгөөд зардлыг 2027 оны БОМТ-д тусгана.

14.2 Компанийн нэгжийн оролцоо

БОМТ-ийн хэрэгжилтийг хангахад компанийн дараах нэгжүүд оролцоно:

- **ХАБЭА хариуцсан менежер:** БОМТ-ийн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хөдөлмөр хамгааллын шаардлагатай уялдуулах;
- **Үйлдвэрийн менежер,:** тэсрэх бодисын үйлдвэрлэл, хадгалалтын аюулгүй ажиллагааны дэглэмийг хангах;
- **Нягтлан бодогч:** БОМТ-ийн санхүүжилт, байгаль хамгааллын зардлын тайлан гаргах;
- **Гүйцэтгэх захирал:** БОМТ-ийн нийт хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, шаардлагатай нөөцийг хуваарилах.

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Байгаль орчны дотоод аудит хийх	-	—	—	—	✓
2027 онд хийх байгаль орчны төлөвлөгөөт аудитын бэлтгэл хангах, гүйцэтгэгч сонгох	-	—	—	—	✓
Нийт ажилчдын ХАБЭА, байгаль орчны сургалт	-	✓	—	—	✓
БОМТ-ийн хэрэгжилтийн тайланг БОУАӨЯ-нд цахимаар (eic.mn) илгээх	-	—	—	—	✓

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Орон нутгийн захиргаатай хамтарсан уулзалт, тайлан	-	—	—	—	✓

15. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННҮ-ний тодотголыг 2023 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Шарын гол сумын Санжинт багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн (хурлын тэмдэглэл №01). Иймд төлөвлөгөөний хэрэгжилтийг тус багийн иргэдэд жил бүр танилцуулж, тэдний санал хүсэлтийг бүртгэн дараа оны төлөвлөгөөнд тусгана.

Хүснэгт 13. БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОМТ-ийн биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах ажилтан
Дархан-Уул аймгийн байгаль орчны асуудал хариуцсан газар	Жилийн тайлан бичгийн хэлбэрээр, цахимаар болон биечлэн хүргэх	БОМТ-ийн жилийн хэрэгжилтийн үр дүн, ОХШХ-ийн үзүүлэлт, зардлын тайлан	IV улиралд	Дотоод зардал	ХАБЭА хариуцсан менежер
Шарын гол сумын Засаг захиргаа	Тайлан хүргэх, хэлэлцүүлэг	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний явц, нөхөн сэргээлтийн хэрэгжилт	IV улиралд	Дотоод зардал	Гүйцэтгэх захирал, ХАБЭА хариуцсан менежер
Санжинт багийн иргэдийн нийтийн хурал	Хурлаар танилцуулах, санал авах	БОМТ-ийн хэрэгжилт, ОХШХ-ийн дүн, иргэдийн санал хүсэлт	IV улиралд	Дотоод зардал	ХАБЭА хариуцсан менежер
Орон нутгийн иргэд, нөлөөлөлд өртөгч талууд	Байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудас, орон нутгийн сонин	Байгаль орчны хамгаалллын арга хэмжээ, орчны чанарын мониторингийн үр дүн, ногоон байгууламжийн ажлын явц	I улиралд (3 дугаар сарын дотор), жил бүр	Дотоод зардал	ХАБЭА хариуцсан менежер
БОУАӨЯ	Байгаль орчны	БОМТ-ийн	IV улиралд	Дотоод	ХАБЭА хариуцсан

БОМТ-ийн биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах ажилтан
	мэдээллийн цахим сан (eic.mn)	нийт хэрэгжилт, ОХШХ-ийн үзүүлэлт		зардал	менежер

16. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ

Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн арга хэмжээний нийт зардлын хуримтлал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дэд хэсэг	Зардал, ₮	Тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (агаар, ус, хөрс, биологийн олон янз байдал)	1,850,000	6.1–6.4 дэх хэсгийн нийт
2	Нөхөн сэргээлт, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	4,000,000	10 га талбайн техникийн болон биологийн нөхөн сэргээлт, 50 мод
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	Мод тарих зардал 7 дугаар бүлэгт, арчилгааны зардал 6.4 дэх хэсэгт тусгагдсан
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	Шаардлагагүй
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	Шаардлагагүй
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	981,000	Аянга хамгаалалтын шалгалт, хэмжилт; анхны тусламж, асгаралтын багц
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	300,000	Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар устгуулах
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	2,000,000	Агаар, ус, хөрсний шинжилгээ (34 дээж)
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-	Дотоод аудит, сургалт, тайлагнал
10	БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	-	Нийтэд мэдэгдэх
	НИЙТ ДҮН	**9,131,000**	

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын 50 хувьтай тэнцэх 4,565,500 төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулна.

17. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тухайн ажилд шаардагдах нөөц, зардал, цаг хугацаа болон сөрөг нөлөөллийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан ач холбогдлын эрэмбээр эзлэх жинг тодорхойлсон. Гүйцэтгэх ажил тус бүрийг 0–100%-иар үнэлж, харгалзах жинд үржүүлж, нийлбэрээр гүйцэтгэлийн нийт хувийг тооцно.

Хүснэгт 15. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Бүлэг	Бүлгийн нэр	Төлөвлөсөн ажил	Шалгуур (хяналтын үзүүлэлт)	Эзлэх жин (%)	Гүйцэтгэл (%)
6.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Хуурайшилт ихтэй үед шаардлагатай бол усалгаа хийх; цогцолбор доторх замд хайрга дэвсэх; тоног төхөөрөмжийн техникийн үзлэг хийлгэх	Хайрга дэвссэн ажлын акт, фото зураг; техникийн үзлэгийн баримт бичиг байна	10	
6.2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Ундны усыг зөвшөөрөлтэй эх үүсвэрээс авах; усны савыг ариутгах; ахуйн бохир усыг зайлуулах	Худалдан авалтын баримт, савны ариутгалын бүртгэл, бохир ус зайлуулсан баримт байна	10	
6.3	Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Тээврийн хэрэгслийг тогтоосон замаар явуулах; засвар, тос солих ажлыг зориулалтын талбайд хийх; хог хадгалах талбайг тохижуулах	Зөрчилгүй ажилласан байх; хог хадгалах талбайг тохижуулсан акт, фото зураг байна	8	
6.4	Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах	Тарьсан модны 85%-иас доошгүй амьдралтыг хангах; хатаж үхсэн модыг нөхөн тарих	Мод арчилсан ажлын тайлан, фото зураг байна	7	
7	Нөхөн сэргээлт	10 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх; 50 ширхэг мод тарих	Нөхөн сэргээлтийн ажлын акт, мод тарьсан акт, фото зураг байна	10	
8	Дүйцүүлэн хамгаалах	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих; орон нутгаас заасан талбайг нөхөн	Тус хөдөлгөөний бүртгэл, нөхөн сэргээлтийн акт, фото зураг байна	8	

Бүлэг	Бүлгийн нэр	Төлөвлөсөн ажил	Шалгуур (хяналтын үзүүлэлт)	Эзлэх жин (%)	Гүйцэтгэл (%)
		сэргээх			
11	Осол, эрсдэлийн менежмент	Галын аюулгүй байдлын сургалт жилд 2 удаа явуулах; ХАБЭА-н сургалт явуулах; аянга зайлуулагчийн шалгалт, газардуулгын хэмжилт хийлгэх; анхны тусламжийн иж бүрдэл, асгаралтын багц байршуулах	Сургалтын ирцийн бүртгэл, хэмжилтийн дүгнэлт, худалдан авалтын баримт байна	12	
12	Хог хаягдлын менежмент	Хог хаягдал ангилан ялгах; аюултай хог хаягдал устгах гэрээ байгуулах	Ангилалтын баримт, гэрээний хуулбар байна	10	
13	ОХШХ	Агаар (4 цэг), гадаргын ус (4 цэг), ундны болон худгийн ус (2 цэг), хөрс (4 цэг)-ний шинжилгээг хуваарийн дагуу хийлгэх	Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт байна	15	
14	Удирдлага зохион байгуулалт	Дотоод аудит хийх; жилийн тайлан гаргах; ОХШХ-ийн мэдээлэл оруулах; төлөвлөгөөт аудитын бэлтгэл хангах	Аудитын дүгнэлт, тайлан хүргүүлсэн баримт байна	10	
			НИЙТ	**100%**	

18. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. "Монмаг" ХХК-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээ

Хавсралт 2. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл (№895)

Хавсралт 3. Цогцолборын байршлын зураг (GoogleEarth)

Хавсралт 4. Галын дүгнэлт (№0002773)

ХАВСРАЛТ 1

Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан, тэмдэг
Худалдаа хөгжлийн банк	Төгрөгийн	499005737	Ч.Поотой
Худалдаа хөгжлийн банк	Валютын	499009833	Ч.Поотой

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тэмдэг
1.	Гадаад плоттчийн төлөөлөгч хасагдав.	2007.03.10	Б.Цэцэг
2	1 жилийн хугацаагаар үйл ажиллагаа эрхлэхийг бүртгэв.	2008.12.10	Ц.Цэдэнсэрж
3	1 жилийн хугацаагаар үйл ажиллагаа эрхлэхийг бүртгэв.	2009.12.21	Н.Оюунхүү
4	1 жилийн хугацаагаар үйл ажиллагаа эрхлэхийг бүртгэв.	2011.01.06	Н.Энхбат
5	Ажиллах хугацаа 2013.01.15-ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2012.01.13	Ц.Булэгсүх
6	Ажиллах хугацаа 2013.01.15 -ний өдрөөс 2014.01.15 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2013.01.22	Э.Мөнхзаяа
6	Ажиллах хугацаа 2014.01.15 -ний өдрөөс 2016.01.15 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2014.01.27	Э.Мөнхзаяа
7	Худалдаа хөгжлийн банк банкны 499231961 тоот валютын дансыг бүртгэв ХААН банк банкны 5173023434 тоот төгрөгийн дансыг бүртгэв ХААН банк банкны 5173023445 тоот валютын дансыг бүртгэв ХААН банк банкны 5173023456 тоот валютын дансыг бүртгэв	2015.06.23	Н.Цэжиддулам
8	Ажиллах хугацаа 2015.01.15 -ний өдрөөс 2018.01.15 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2016.01.27	А.Мөнхсайхан
9	Ажиллах хугацаа 2018.01.15 -ний өдрөөс 2020.01.15 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2018.01.24	Ж.Оюумаа
10	Ажиллах хугацаа 2020.01.15-ний өдрөөс 2022.01.15-ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2020.01.08	Г.Алтай
11	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 486651.7 мян.төг-р нэмэгдэж нийт 687500 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2020.02.06	Г.Алтай
12	Хувьцаа эзэмшигч 2 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.02.06	Г.Алтай
13	Зургаадахь хороотой Баатархайрхан-г Гүйцэтгэх захирал-р сонгосон (томилсон)-ыг бүртгэв.	2020.02.06	Г.Алтай
14	Үйл ажиллагаа эрхлэх хугацаа хугацаагүй болгов.	2022.01.17	М.Мөнгэлжин
15	Пүнцэр хороотой Тэвшинжаргал-г Гүйцэтгэх захирал-р сонгосон (томилсон)-ыг бүртгэв.	2024.10.18	П.Оюунцэрэн

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

ХАВСРАЛТ 1 (үргэлжлэл)

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2006.05.01
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9019018124
/Улсын бүртгэлийн дугаар/

2075318
/Регистрийн дугаар/

Монмаг

ХХК - Гадаадын хөрөнгө оруулалттай

/Хуулийн этгээдийн нэр, харьяалагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тушаал	А-463	1991.08.16
/шийдвэрийн нэр/	*/дугаар/*	*он, сар, өдөр*

242900	Энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх, борлуулах
/код/	*/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/*

/код/	*/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/*	
3	3	218,848.3
хувьцаа	*/гишүүдийн тоо/*	*/өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/*

Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Интерком Б корпус - 3 давхарт, утас1:319162, утас2:99114314, факс:324044

/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР УЛСЫН БҮРТГЭЛИЙН АЛБА УХА0175

Улсын бүртгэлийн алба

/бүртгэсэн байгууллагын нэр/

ХАВСРАЛТ 2

СУНГАЛТ:

Тусгай нөхцөл шаардлага:

СУНГАЛТ:

Тусгай нөхцөл шаардлага:



ХАВСРАЛТ 2 (үргэлжлэл)

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

2023 оны .07. сарын .06. өдөр Дугаар .895.... Улаанбаатар хот

Эрхлэх үйл ажиллагааны төрөл	Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	"МОНМАГ" ХХК
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Амарын гудамж, Интерном ХХК-ийн байр
Регистрийн дугаар	2075318
Тусгай зөвшөөрлийн хугацаа	5 /Тав/ жил
Тусгай нөхцөл, шаардлага	Холбогдох хууль, журам, дүрэмд заасан бүх шаардлагыг хангаж ажиллах.

МОНГОЛ УЛС 242

2024.12.12 ... он ... сар ... өдөр Бүртгэлийн № ...
Нийслэлийн нотариатын газрын нотариатч ... энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.
Нотариатч .....

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 202.3 оны .07. сарын .06. өдрийн А/257дугаар тушаалыг үндэслэн олгов.


УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД Ж.ГАНБААТАР

ХАВСРАЛТ 3



ТЭСРЭХ
БОДИСЫН
ҮЙЛДВЭР
АГУУЛАХЫН
ЦОГЦОЛБОРЫН
БАЙРШИЛ

ХАВСРАЛТ 4



Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
11 дүгээр сарын 10-ны өдрийн 75 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0002773

Иргэн, хуулийн этгээдийн нэр: "Монмаг" ХХК

Хаяг: Шарын гол сум, Санжинт баг

Эрхлэх үйл ажиллагааны чиглэл:

Эгийн тэсрэх бодис үйлдвэрлэх, борлуулах

Барилга байгууламж, газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн хэрэгслийг ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.

/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3.19 дүгээр зүйлийн 19.2, 23 дугаар зүйлийн 23.3./

/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Хяналт шалгалт хийсэн 2026 он 04 сар 25 өдөр

Олгосон: 2026 он 05 сар 12 өдөр

Хүчинтэй хугацаа: 2027 он 05 сар 11 өдөр хүртэл

Баталгаажуулсан:

Дархан-Уул аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

дарга Хурандаа цолтой А.Алтансүх

Дүгнэлт олгосон:

Дархан-Уул аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

Гал түймрийн улсын хяналтын байцаагч: Ахмад цолтой Н.Баасанхүү

/тэмдэг дарна/